МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.07.30 № 06

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД Ц.ТУВААН ТАНАА

Асуулга тавих тухай

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн Цагаан даваа нэртэй газарт ашигт малтмалын ашиглалтын MV-018291, MV-018293 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшин, “Хөшөөтийн чулуун нүүрсний ордын 3үүн хэсгийг ил уурхайн аргаар ашиглах” төслийг хэрэгжүүлж буй Тефис майнинг ХХК-ийн үйл ажиллагаанд хангалтгүй байгаа талаар орон нутгийн иргэдийн санал, гомдол удаа дараа ирсээр байна.

Иймд, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дугаар зүйлд заасныг үндэслэн Танд хандаж, дараах асуулгыг тавьж байгаа юм. Үүнд:

Нэг.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1.1.Тефис майнинг ХХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл бүхий тус хоёр талбайн хамаарах нутагт Дарви, Цэцэг сумын малчид нутаглаж байна. Малын бэлчээр, малчдын өвөлжөө, хаваржааг хэрхэн хамгаалж үлдээж байгаа талаар;

1.2.Тухайн газарт 20 овогт 47 төрөл, 56 зүйл цоргот дээд ургамал бүртгэгдсэн. Уурхайн олборлолтын явцад 347,06 га талбайн хөрс хуулагдаж овоолгод шилжинэ. Эдгээр ургамал дахин нөхөн сэргээгдэж, шимт хөрсөн бүрхэвч, гадаргуугийн хэлбэр анхны байдалдаа буцаж орох, газрын хэвлийн бүрэн сэргэх боломж бий эсэх талаар;

1.3.Олон тооны техник ашиглалт, нүүрс олборлолтоос үүдсэн нүүрсний, шороон үүсмэл тоосжилтын уршгийг бууруулах талаар;

1.4.Тусгай зөвшөөрөл эзэмшдэг өндөр уулын бүслүүр нутагт 13 багт хамаарах 41 овгийн 108 зүйл амьтан амьдардаг. Эдгээр нь 34 зүйл хөхтөн, 56 зүйл шувууд, 4 зүйл мөлхөгч, хэвлээр явагч амьтад юм. Монгол Улсын улаан номд орсон аргал, янгир, цоохор ирвэс, эрээн хүрнэ болон нэн ховордож, олон улсын хэмжээнд хамгаалагдсан шилүүс, мануул, сохор элээ, Цармын бүргэд, нөмрөг тас, ёл, шонхор, Өвөгт тогоруу гэх мэт олон тооны амьтад байгаа нь туйлын харамсалтай юм. Эдгээр амьтадад учирч болох эрсдэл байгаа эсэх, хамгаалах талаар;

20[illegible]

1.5.Байгал хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд нутгийн иргэдийн төлөөлөл, олон нийтийн хяналт хэрэгжүүлж байгаа талаар.

Хоёр. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

2.1.Олборлож буй түүхий нүүрсээр баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа эсэх;

2.2.Бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй бол, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35 дахь заалтыг хэрэгжүүлж буй эсэх.

Гурав. Нутгийн захиргааны байгууллага, иргэд хоорондын хамтын ажиллагаа

3.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулсан эсэх;

3.2.Гэрээ ил тод байгаа эсэх, байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх, дэд бүтэц тавих, ажлын байр, хандив тусламжийн асуудлаар гэрээнд хэрхэн туссан;

3.3.Тусгай зөвшөөрөлд заагдсан газар нутагт амьдарч буй иргэдтэй олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан эсэх;

3.4.Нутгийн иргэдээс хэдэн хүнийг, ямар цалин хөлстэй ажиллуулж буй судалгаа зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их хурлын тухай хуульд заасан хугацаанд ирүүлж, Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Э.БОЛОРМАА

20240919